

Академич П.Нямдаваагийн 70 насны ойд зориулав**АКАДЕМИЧ МАХБАЛ ОВОГТ ПАГВАЖАВЫН НИЯМДАВАА**

Монгол Улсын ШУА-ийн болон МАУА-ийн гишүүн, академич Махбал овогт Пагважавын Нямдаваа 70 нас хүрлээ.

Пагважавын Нямдаваа нь 1947 оны нэгдүгээр сарын 11-нд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг “Хайлааст” хэмээх гэзар төрсөн. 1971 онд Монгол Улсын Анагаах ухааны дээд сургуулийн эмчилгээний ангийг төгссөн. Хүний их эмч, анагаах ухааны вирус судлалаар мэргэшсэн.


1977 онд БНАГУ-ын Берлин хот дахь Хумбольдтын нэрэмжит их сургуульд (Humboldt Universität, Berlin) “Миксовирусийн экологийг болжморын ангийн зэрлэг шувуун дээр судалсан дүн” (Untersuchung zur Ökologie der Muxoviren bei wildlebenden Vogelarten der Ordnung Passeriformes-Sperlingsvogel) сэдвээр анагаах ухааны докторын, 1989 онд ОХУ-ын Анагаах ухааны академийн Д.И.Ивановскийн нэрэмжит Вирус судлалын хүрээлэнд “Вируст халдварын өвчлөл ба хүн амын вирусийн эсрэг дархлалын түвшин [БНМАУ-ын жишээн дээр]” (Заболеваемость вирусными инфекциями и популяционный иммунитет к вирусам [на примере МНР]) сэдвээр анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. 1984 онд АНУ-ын Нью Йоркийн Шинжлэх ухааны академийн гишүүн, 1991 онд Монгол улсын ШУА-ийн гишүүнээр, 2005 онд Монголын Анагаах ухааны Академийн гишүүнээр тус тус сонгогдож, 1995 онд Тайланд улсын Рангситын Их сургууль, 2001 онд Монгол улсын Анагаах ухааны их сургууль хүндэт доктороор өргөмжилсөн. 1997 онд Монгол улсын Эрдмийн зэрэг цол олгох дээд комиссоос профессор цол хүртээсэн байна.

1971-74 онд Монгол улсын Анагаах ухааны дээд сургуулийн Эрүүл ба эмгэг физиологийн тэнхимд багшаар, 1978-1997 онд ЭХЯ-ны Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институтэд тасаг, лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирлаар, 1997 оноос ШУА-ийн тэргүүлэгч гишүүн, Анагаах ухааны бага чуулганы даргаар, 1987-1991 онд Эрүүлийг хамгаалах яамны орлогч сайд, улсын ариун цэврийн ерөнхий байцаагчаар, 1991-1996 онд Монгол улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар, 1998-2000 онд Монгол улсын ерөнхийлөгчийн Нийгмийн бодлогын зөвлөхөөр, 2000-2004 онд УИХ-ын гишүүн, Монгол улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар ажилласан. 2004-2005 онд ЭМЯ-ны Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн захирлын эрдэм шинжилгээний зөвлөх, 2005 онд МАУА-ийг үүсгэн байгуулж, 2005-2013 онд МАУА-ийн ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж, 2005-2014 онд “Томуугийн тандалтын сүлжээг байгуулан хөгжүүлэх” Монгол-Америкийн хамтарсан төслийн захирлаар тус тус ажиллажээ.

Академич П.Нямдаваа нь дэлхий нийтийн глобальчлалын өнөө үед бусад орны эрдэмтэдтэй нээлттэй харилцах боломж, орчин бий болгох зорилгоор ШУА, МАУА-ийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой анхаарч, БНХАУ-ын Анагаах ухааны Академийн Эмгэгтөрөгчийн биологийн хүрээлэнтэй анагаах ухааны вирус, нян судлалаар, ХБНГУ-ын Мюнстер хот дахь Вестфалийн Вильхельмийн Их Сургуулийн Молекул Вирус судлалын хүрээлэн (Institut fuer Moleculaeren Virologie)-тэй шинээр болон сэргэн тархаж

буй халдварын чиглэлээр, Японы Тохоку их сургуультай залуу судлаачдыг сургах бололцоог бий болгох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх чиглэлээр, Хятадын Анагаах ухааны академийн харьяа Анагаах Ухааны Мэдээллийн хүрээлэнтэй “Монголын Анагаах Ухаан” мэргэжлийн сэтгүүлийн онлайн сан бүтээх, хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлж, үр дүнтэй зохион байгуулж ажилласан юм. Түүнчлэн Францын Мерьёгийн сантай хамтарсан судалгааг эхлүүлэх, Оросын Анагаах

Ухааны академитай бие даасан хамтын ажиллагааны гэрээ байгуулж, АНУ-ын Флорида, Дюкийн их сургуультай хамтран Монгол улсад шинээр сэргэж буй халдварын судалгааг “Нэг эрүүл мэнд” төслийн хүрээнд хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, МАУА-ийг Дэлхийн Анагаах ухааны Академиудын холбооны гишүүн академи болгон бэхжүүлж, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалт зохион байгуулахад ихээхэн анхаарал хандуулан ажилласан байна.



Зураг 1

Монгол улсын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, МАУА-ийн ерөнхийлөгч, (тэр үеийн нэршилээр) академич П.Нямдаваа, Оросын анагаах ухааны академи (ОАУ)-ийн ерөнхийлөгч, академич И.И.Дедов нар Эрдэм шинжилгээний салбарт хамтран ажиллах тухай бие даасан гэрээ зурж байгаа нь (2011.05.31)

Зураг 2

Японы Тохоку их сургуультай Монголын Анагаах ухааны Академийн хооронд анагаах ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, анагаах ухааны бусад олон салбарт хамтран ажиллах, залуу судлаачдыг Японд сургах бололцоог бий болгов. (2010.03.24)





Зураг 3

БНХАУ-ын Анагаах Ухааны Академийн Эмгэгт өрөгчийн биологийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, анагаах ухааны вирус, нян судлалаар хамтран ажиллахаар тохиролцов. (2010.07.9)

Зураг 4

БНХАУ-ын Анагаах Ухааны Академийн Эмгэгт өрөгчийн биологийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсаны дараа




1978 онд ЭАХНСУИ-д Томуугийн үндэсний төвийг байгуулан ДЭМБ-тай хамтран ажиллах үндэсний төвөөр бүртгүүлсэн ба 2005-2014 онд ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторийг түшиглэн АНУ-ын төслийн дэмжлэгтэйгээр лабораторид суурилсан амьсгалын замын цочмог халварын үүсгэгчийн тандалтын тогтолцоог бий болгон бэхжүүлж, ДЭМБ-ын тавьж буй шаардлагыг хангах түвшинд хүргэн, манай орны нөхцөлд вирүст халдварын тандалтыг нуклейн хүчилд суурилсан аргаар тогтмол хийж, 7 хоног тутам он-лайн хэлбэрээр монгол ба англиар мэдээлэх загвар бий болгож,

шавь нарынхаа хамтаар томуугийн болон амьсгалын замын бусад вирүсийн 400 гаруй нуклеотидын дарааллыг GenBank-инд бүртгүүлжээ. П.Нямдаваа 1985-1988 онд ДЭМБ-ын Зүүн Өмнөд азийн бүсийн хорооны эрүүл мэндийн зөвлөх хорооны гишүүн, 1990 онд ДЭМБ-ын Ерөнхий Ассамблейн дэд ерөнхийлөгч, 1991 онд ерөнхийлөгч, 1992-1995 онд ДЭМБ-ын Гүйцэтгэх хорооны гишүүн, 2003-2004 онд Вакцин, дархлаажуулалтын глобал Альянс (GAVI) олон улсын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, 2009-2014 онд Томуу болон амьсгалын замын бусад вирүст халдварыг судлах олон улсын

холбоо (ISIRV) байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байсан ба 2014 оноос одоог хүртэл ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн “Улаанбурхан өвчний тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулах бүсийн хороо”-ны гишүүнээр ажиллаж байна.

Академич П.Нямдаваа нь зөвхөн Монголдоо төдийгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Дэлхийн олон орны

мэргэжил нэгтнийхээ итгэлийг нь хүлээсэн эрдэмтэн юм. 2016 оны 12 дугаар сарын байдлаар монгол, англи, орос, герман хэлээр 1000 гаруй бүтээл хэвлүүлсний дотор “Бүтээлийн товчоон” 11 боть зэрэг 30 гаруй ном, эрдэм шинжилгээний 200 гаруй өгүүлэл багтаж байна. Академич П.Нямдаваагийн удирдлагаар 7 судлаач шинжлэх ухааны докторын, 21 судлаач анагаах ухааны болон биологийн ухааны



Эрдмийн цуврал бүтээлийн товчоон П.Нямдаваа, (2008)

докторын, 6 судлаач магистрын зэрэг хамгаалжээ.

1987-2004 онд төр, засгийн удирдах ажилд томилогдож, Монгол улсыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжих үеийн эрүүл мэндийн тогтолцоог 10 гаруй жил удирдаж, Монгол улсын эрүүл мэндийн салбарыг зах зээлийн нийгэмд төлөвшүүлэн хөгжүүлэх, эрүүл мэндийн хууль эрх зүйг боловсронгуй болгоход үр бүтээлтэй ажилласан, ихийг бүтээсэн эрдэмтэн юм. 1966 онд Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, 1996 онд “Алтан гадас” одон, 2001 онд “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” 2007 оны 11

дүгээр сарын 22-ны 246 дугаар зарлигаар “Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан” цол хүртээсэн байна.

2015 онд Анагаах ухааны салбарт олон жил идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, Монгол улсад шинжлэх ухаан технологи, эрүүл мэндийн талаарх үндэсний бодлого, эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, түүний технологийг нэвтрүүлэхэд өөрийн оюуны хүчийг дайчлан ажиллаж, анагаах ухааныг хөгжүүлэхэд болон шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, ШУА-ийн “Хубилай хаан” медалиар шагнасан юм.



Шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр, нээлт

- Палео-арктикийн зэрлэг шувуунаас анх парамиксовирус ялгаж, биологийн болон дүрс судлалын төрх, уургийн бүрэлдэхүүнийг нь судлан тогтоосон (1974-1977);
- БНМАУ-д вирусийн экологи, молекул биологийн судалгааг эхлүүлж, зэрлэг шувууд, зарим мэргэгчдийн популяцид ортомиксовирус, хепаднавирус, зарим арбовирусийн манай улс дахь тархалтын ареалыг тогтоож, зэрлэг хөхтөнд шимэгчлэгч үе хөлтнүүдээс хачигт энцефалитын вирус, Гетатөст флавиовирус, зэрлэг шувуудаас ортомиксовирус, тарваганаас хепаднавирус анх илрүүлж, удамшил-биологийн зарим төрхийг нь судласан (1978-1998);
- ЗХУ, БНАГУ-ын судлаачид, шавь, хамтран ажиллагсадтайгаа хамтран манай хүн амын дотор зонхилон тохиолдож буй А, В(Бэ), С(Цэ), D(Дэ) вирусүст хепатит, улаанбурхан, улаанууд, томуу, полиомиелит, арбовирусүст, херпесвирусүст болон ретровирусүст халдваруудын дархлал тогтоц, вирусийн нутгийн омгуудын ийлдэс судлалын болон молекул биологийн төрхийг судлах ажлыг эхлүүлж, одоо АНУ, ОХУ, Японы судлаачидтай хамтран Монголд ялгасан вирусийн омгуудын генотипийн судалгааг удирдан хийж байна (1978 оноос одоог хүртэл);
- Монгол хүүхдүүдэд улаанбурхны вирусийн эсрэг дархлал тогтцын онцлогийг судласны үндсэн дээр 9 саргайд нь эхний тунг, зургаан сарын дараа хоёрдох тун тарих товлолыг анх нэвтрүүлснээр (1980-1989) өвчлөл, эндэгдлийг нь олон арав дахин бууруулж, энэ халдварын тахалт тархалтыг таслан зогсоох нөхцлийг бүрдүүлсэн (2005 оноос);
- 1982 оны дэгдэлтийн үед Монгол өвчтөнөөс анх полиомиелитын вирус ялган удамшил-биологийн төрхийг нь судлаж, энэ өвчний эсрэг дархлаажуулалтын шинэ товлол нэвтрүүлэн, полиомиелит өвчнийг устгах ДЭМБ-ын хөтөлбөр, Монгол улсад уг өвчнийг устгасныг баталгаажуулах судалгаа, практик үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлсэн (1982-2000);
- Монгол улсад гадаад орчны вирус судлалын судалгааг удирдан эхлүүлж, А хепатитын вирусийг оруулан гадаад орчны энтеровирусийн бохирдлын түвшинг манай орны нөхцөлд анх тогтоосон (1982-1990);
- В вирусүст хепатитын эсрэг эх орны вакцин боловсруулах, өргөн дархлаажуулалт нэвтрүүлэх, дархлал тогтоцын түвшин, вакцинаас дайжих мутантын тархалт, вакцинд үл хариуцах байдлыг судлах ажлыг удирдан хэрэгжүүлснээр (1980 оноос одоог хүртэл) вирусүст хепатитын өвчлөл ба эндэгдэл, нэн ялангуяа В вирусүст хепатитаас уламжилсан өвчлөл, энэдэгдэл тууштай буурах нөхцлийг бүрдүүлэв;
- Вирусүст халдварын эмчилгээнд интерферон, вирусийн эсрэг хими-заслын зарим бэлдмэл (ремантадин, оксолин, ацикловир, оселтамивир зэрэг) нэвтрүүлэх ажлыг удирдан гүйцэтгэв (1978 оноос);
- Монголд ДОХ/ХДХВ-ийн онош, сэргийлэлт, менежментийн иж бүрэн судалгааг удирдан эхлүүлэв (1986-1996);
- Холландын судлаачидтай хамтран сүрьеэгийн нянгийн Зүүн азид түгээмэл тархсан (хожмоо Бээжин генотип нэр авсан) хэвшинжийг нээлцэж, Монгол улсад ялгасан сүрьеэгийн нянгийн удамшлын

- төрхийг антибиотикт мэдрэг чанарын үзүүлэлттэй жишин судлах ажлыг удирдан эхлүүлсэн (1994 оноос);
- Их Британий судлаачидтай хамтран монголчуудын У хромосомын полиморфизмын зарим асуудлыг судлаж, генотипийн шинэ хувилбарууд илрүүлсэн ба одоо ОХУ-ын судлаачидтай хамтран хүний У хромосом, мт-ДНХ-ийн полиморфизмыг судлаж байна (1997 оноос одоог хүртэл);
 - Монгол улсад эрүүл мэндийн даатгал, өрхийн эмчийн, эмийн болон эмчилгээний чанарын хяналтын, халдварт өвчинтэй тэмцэх нэгдсэн тогтолцоог бий болгон хөгжүүлэх, эсэн мэнд амаржихуйн, үндэсний эмийн болон тамхидах тахалтай тэмцэх бодлого, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага үүсэн хөгжих онол, эрхзүйн үндэслэлийг хамтран ажиллагсадтайгаа боловсруулан хэрэгжүүлэв (1990-2003);
 - АЦХаХ (SARS) өвчний импортлогдсон дэгдэлтийг таслан зогсоох ажлыг удирдаж, эмнэлзүйн болон вирус судлалын онош, менежментийн судалгааг эхлүүлсэн (2003-2004);
 - Томуугийн вирусийн лабораторийн тандалтыг сүлжээ байгуулж, шат дараалан бэхжүүлж, вирусийн геномын бүтцийг эх орондоо бодит-хугацааны ПГУ (rt-PCR), секвенсер ашиглан судлах эхлэлийг тавьж, олон улсын нуклеотидын дарааллын сан GenBank-д Монгол улсад ялгасан томуугийн болон амьсгалын замын бусад вирусийн 400 гаруй генийн дарааллыг оруулсан байна. (1978

оноос одоог хүртэл).

Академич П. Нямдаваагийн эрдэм шинжилгээний бүтээлийн чансааг авч үзвэл: 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар англи хэл дээр нийтлэсэн (GoogleScholar) бүтээлээс 2667 судлаач иш татсан байна. 2012 оноос хойших 5 жилд 1465 удаа иш татагдсан байна. Академич П.Нямдаваагийн бүтээлийн дотор 10 ба түүнээс дээш удаа иш татагдсан бүтээл 34, үүнээс 2012 оноос хойш нийтлэгдсэн 29 бүтээл байна.

Академич П.Нямдаваа эрдэм судлалын хэд хэдэн ажлын эрдэм шинжилгээний удирдагч, МАУА-ийн дэргэдэх Анагаах ухаанаар шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, АШУҮИС-ийн дэргэдэх анагаах ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн Орлогч дарга, ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн болон Хавдар судлалын үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Түүнчлэн “Монголын Анагаах ухаан” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн дэд эрхлэгч, ОХУ-ын “Вопросы вирусологии” болон “Эпидемиология и вакцинопрофилактика” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гадаад гишүүнээр ажиллаж байна.

Академич П.Нямдаваа Танд 70 насны ойн чин сэтгэлийн мэнд хүргэхийн ялдамд Монголын болон дэлхийн шинжлэх ухаанд улам ихийг бүтээж, эрүүлийг хамгаалах, төр нийгэм, олон нийтийн ажил болон Эрдэм судлалын ажилд тань өндөр амжилт хүсэж, эрүүл энх, урт удаан насалж, таны шавь нар болон залгамж халааг авах судлаач бидэнтэйгээ эрдэм судлын арвин их туршлагаасаа хуваалцан явахын өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

Эрдмийн цагаан буян дэлгэрч, номын арвин хур цаг ямагт бууж байх болтугай.

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
“ШУА-ИЙН МЭДЭЭ СЭТГҮҮЛ”-ИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**